

2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН





АГУУЛГА

КОМПАНИЙН ТУХАЙ | ОРШИЛ

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ | О. НАРАНДЭЛГЭР

ОНЫ ТОВЧООН

АРИЛЖАА

ХАМТЫН АЖИЛЛАГАА

МАРКЕТИНГ

ТӨЛБӨР ТООЦОО | ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ГИШҮҮНЧЛЭЛ | ЗАГВАР ХОРШОО

ДҮГНЭЛТ

ЦААШДЫН ТӨЛӨВ





КОМПАНИЙН ТУХАЙ

Оршил

Хөдөө аж ахуйн бирж нь Монголын хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжих тогтолцоог бий болгон хөгжүүлэх замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын орлогыг өсгөх нөхцөлийг бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Компанийн дунд хугацааны /2022-2026/ стратеги төлөвлөгөө”-г, 12 дугаар сарын 30-ны өдрийн 18 дугаар тогтоолоор “Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө”-г баталсан бөгөөд эдгээр богино, дунд хугацааны төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бүтэц орон тооны дагуу компани нь 5 хэлтэс, 36 ажилтантай, биржийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бодлого, чиглэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



АЛСЫН ХАРАА, БИДНИЙ ИРЭЭДҮЙ

Эрхэм зорилго

Монголын хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжих оновчтой тогтолцоог бий болгох замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын орлогыг өсгөх нөхцөлийг бүрдүүлнэ.

Зорилт

Бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, Зах зээлд оролцогчдын тоог нэмэгдүүлэх, Ложистикийн төвийг бий болгох, зах зээлийн дэд бүтцийг сайжруулах, Зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлэх, Компанийн засаглалыг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

Үнэт зүйлс

Нэр хүнд, Хариуцлага, Үнэнч шударга зарчим, Мэргэшсэн боловсон хүчин, Ёс зүй, Дэвшилтэт технологи, Багаар ажиллах чадвар



ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Бирж байгуулагдсан цагаас хойш нийт 5,9 их наяд төгрөгийн арилжаа зохион байгуулснаар Монгол улсад бэлтгэгдэж буй хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн статистик тоо хэмжээ үнэн зөвөөр гарч, тус салбарын далд эдийн засаг багасаж, тодорхой хэмжээний мөнгөн урсгал чөлөөлөгдөн төсөвт болон зохицуулах байгууллагад төвлөрснөөр эдийн засагт бодит хувь нэмрээ оруулж байна.

Бид арилжаа, клиринг, төлбөр тооцооны олон улсын шаардлагад нийцсэн програм хангамж, технологийн шинэчлэл хийх зорилгоор блокчэйн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн системийг ашиглалтад оруулаад байна.

Цаашид Монгол улсад хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох, ложистикийн нэгдсэн сүлжээ бий болгож, худалдан авагчид малчид, хоршоод бэлтгэн нийлүүлэгчдээс бараа, түүхий эдийг шууд худалдан авах боломж бүрдүүлэх, үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг зохион байгуулж, арилжааны зах зээлийг сонгодог утгаар нь хөгжүүлэхээр зорин ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн биржтэй хамтран ажилладаг байгууллагууд, хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэгч малчид, хоршоо, үйлдвэр, түүхий эд худалдан авагчид, биржийн гишүүн брокерын компаниудад ажлын амжилт хүсье.



ОНЫ ТОВЧООН



"Русская кожа" хувьцаат нийгэмлэгийн төлөөлөгчид "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-тай 2019 онд байгуулсан Арьс ширэн түүхий эд бэлтгэн, нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай Санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор Монгол Улсад хүрэлцэн ирсэн.



"Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл", "Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо" нартай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.



2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Сүмбэр багт хоршоо байгуулах анхдугаар хурлыг зохион байгуулан 43 гишүүнтэй "Баялаг гүрэм" загвар хоршоо байгуулсан.





Загвар хоршоо 2022 оны 4-р сарын 1-ний өдөр БИРЖИЙН АРИЛЖААНД СУМААСАА ШУУД ОРОЛЦЛОО.



"Хонгор арвижих" хоршоо 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр 77 богц цайвар ноолуурыг биржээр дамжуулан худалдан борлууллаа.



ХОРШООНЫ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ - 2022 үндэсний хөтөлбөр



"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэж Налайх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт Шинэс мод тарив



“Баялаг гүрэм” загвар хоршоонд Японы ОУ-ын хамтын ажиллагааны Жайка төслийн санхүүжилтээр 38,0 сая төгрөгийн хонины ноос хяргах тоног төхөөрөмж хүлээлгэн өглөө.



ХААИС-ийн дэргэдэх Арьс ширний салбарын сургалт, судалгаа инновацын төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.




АРИЛЖАА

2022 оны 6 дугаар 15-ны байдлаар 73 удаагийн арилжаа зохион байгуулж 523 хэлцлээр 3,955.5 тонн ноолуур, 1,938.6 тонн хонины ноос, 946.5 тонн тэмээний ноос, 1,687.6 тонн ямааны завод ноос, 1000 тонн тосны ургамал /рапс/ тус тус арилжиж нийт 575.5 тэрбум төгрөгийн үний дүнтэй арилжаа зохион байгуулсан.

Энэ оны хамгийн өндөр дүнтэй арилжаа 5 дугаар сарын 12-нд 60 тэрбум төгрөг байсан бол, 2 дугаар сарын 09-нд хамгийн бага буюу 3.3 сая төгрөгийн дүнтэй арилжаа хийсэн байна.


Зохион байгуулсан арилжааны тоо (2018-2022 улирлаар)





Бараа түүхий эдийн бэлтгэн, нийлүүлэлтээс хамааралтайгаар I, IV улиралд арилжааны тоо багасаж харин II, III улиралд арилжаа идэвхждэг болно. 2013-2021 оны хооронд ХААБ нь нийтдээ 5 их наяд 689 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа зохион байгуулсан байна.


Арилжааны үнийн дүн (тэрбум ₮)






Арилжааны үнийн дүн (сараар, тэрбум ₮)

2018 2019 2020 2021 2022






2022 оны эхний хагас жилийн арилжааны үнийн дүн /барааны бүлгээр/



2022 оны эхний хагас жилийн арилжсан барааны хэмжээ /барааны бүлгээр/





2022 оны Биржийн арилжаанд 5 брокерын компаниар зуучлуулан 32 харилцагч оролцсон ба нийт 660 ширхэг бараа, түүхий эдийн экспортын тодорхойлолт авсан байна.

2022 онд гадаад валютын ханшийн хэлбэлзэл, ялангуяа гол экспортлогч улс болох Бүгд Найрамдах Хятад Ард Улсын юаны ханш өмнөх онтой харьцуулахад 4.3 хувиар өссөн мөн дэлхийн нийтийг хамарсан цар тахлын улмаас хил гаалийн үйл ажиллагаа хязгаарлагдмал, дотоодын үйлдвэрлэлт, экспортлогч аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон хэдий ч Биржийн арилжааны шимтгэлийн орлогын 90-95 хувийг дангаар бүрдүүлдэг голлох түүхий эд болох ноолуурын ханш тогтвортой байснаар энэ оны арилжааны нийт дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.6 хувиар өссөн байна.

Биржийн арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх, арилжааг илүү боловсронгуй, бодитой зохион байгуулахаар зорин ажиллаж байна.

Энэхүү зорилтын хүрээнд бид орон нутгийн түүхий эд бэлтгэгч хоршоодтой 2021 оноос эхлэн хамтран ажиллаж Хэнтий аймгийн Баян-овоо сумд “ЗАГВАР ХОРШОО”-г байгуулан хөгжүүлж ажилласан. “Баялаг гүрэм” загвар хоршоо нь 2022 оны 3 дугаар сараас эхлэн ямааны ноолуурыг биржээр арилжих бэлтгэл ажлаа ханган, стандартын дагуу анхан шатны тордолт хийж гүйцэтгэн 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр биржээр дамжуулан арилжсан.

Мөн 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Төв аймгийн “Хонгор арвижих” хоршоо өөрсдийн бэлтгэсэн түүхий эдээ биржээр дамжуулан арилжсан байна.





ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь санхүүгийн ил тод, тогтвортой байдлыг хангах, бэхжүүлэх зорилгоор НҮБ-ын Тогтвортой хөрөнгийн биржийн санаачлагын деривативын сүлжээнд 2022 оны 07 дугаар сарын 12-ны өдөр нэгдсэн.

Тус санаачилгад нэгдсэнээр Хөдөө аж ахуйн бирж нь цаашид ногоон түүхий буюу green commodity нэвтрүүлэх, улс орны тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхэд хувь нэмрээ оруулах, бирж болон оролцогч талууд нь байгаль орчин, нийгэм, сайн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх, тайлагнах, энэ чиглэлээр оролцогчдын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэн хэрэгжүүлэх юм.

Тогтвортой хөрөнгийн бирж нь /SSE/ 10 гаруй жилийн өмнө НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан бөгөөд анх үүсгэн байгуулагч таван гишүүнээсээ 100 гаруй бирж болон өргөжсөн. Тус байгууллага нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш хөрөнгийн биржүүд, үнэт цаасны зохицуулагчид болон хөрөнгийн зах зээлийн бусад оролцогчидтой хамтран тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжих чиглэлээр биржүүдэд арга хэмжээ авах олон боломжуудыг тодорхойлж ирсэн. 2021 оноос эхлэн Тогтвортой хөрөнгийн бирж /SSE/ нь дериватив биржүүдийг гишүүнээр элсүүлж эхэлсэн



Дэлхийн банкны санхүүжилтээр 2023 оноос хэрэгжихээр төлөвлөж буй “Ногоон, өрсөлдөхүйц хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (GCAP)” төслийн хүрээнд Хөдөө аж ахуйн биржид үзүүлэх техник туслалцааны ажлын даалгаврыг боловсруулж, ажлын даалгаварт тусгагдсан ажлуудын хүрээнд хийгдэх дэд ажлуудын дэлгэрэнгүй жагсаалтыг РРТ танилцуулгын хамт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны холбогдох ажилтанд хүргүүлж ажиллав. Энэ чиглэлээр 5 удаагийн цахим уулзалт, 2 удаагийн биечилсэн уулзалт зохион байгуулсан.

Мөн тус төслийн дунд шатны үнэлгээний хуралдаанд илтгэгчээр оролцсон байна. Дээрх зээлийн төсөл эхлэхээс өмнө биржид хууль эрх зүйн орчныг сайжруулах техник туслалцааны төсөл хэрэгжүүлэх хүсэлт гаргаж, холбогдох ажлын даалгавруудыг боловсруулж хүргүүлсэн. Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр болох “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөлд Биржийн зүгээс хамрагдах боломжийн талаар санал боловсруулав.



“Русская кожа” хамтын нийгэмлэгийн төлөөлөгчид албан томилолтын хугацаанд Улсын их хурлын дэргэдэх Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, Мал эмнэлгийн ерөнхий газар, Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХХК, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбооны эрх бүхий албан тушаалтнууд болон түүхий эд бэлтгэгч аж ахуйн нэгжүүдтэй уулзаж санал солилцсон ба Үйлдвэр худалдааны “Өлзийт төв” ХХК-иас 20 тонн нойтон, давсалсан арьс ширийг дээж хэлбэрээр худалдан авсан бөгөөд дээжийн хариу холбогдох шаардлагуудыг хангасан байна. Одоогийн байдлаар “Русская кожа” хамтын нийгэмлэгийн зүгээс Өлзийт төвд арьс шир худалдан авахаар үнийн санал ирүүлсэн байна.

Азийн хөгжлийн банкны "Байгалийн баялаг болон Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээнд хийгдэх хөрөнгө оруулалтыг дэмжиж хөдөө орон нутгийн байгаль орчинд дасан зохицох чадварыг нэмэгдүүлж тогтвортой хөгжлийг хангах" төслийн Агробизнесийн зөвлөх Д.Багаажавын хүсэлтээр уулзалт зохион байгуулж Монголын ноолуур болон хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээнд учирч буй хүндрэл бэрхшээл, өртгийн сүлжээн дэх үйл ажиллагааг цахимжуулах боломжийн талаар мэдээлэл солилцов.



“Экспортыг дэмжих төсөл”-өөс хэрэгжүүлж байгаа төслүүдийн талаар санал боловсруулж уулзалт зохион байгуулан Бижрийн зүгээс тус төсөлд хамрагдах боломжийн талаар санал солилцож ажиллав.

Монголын бизнесийн зөвлөлөөс зохион байгуулсан “Монголын тээвэр ложистикийн тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам” хэлэлцүүлэг, Экспортыг дэмжих төслөөс зохион байгуулсан Мэдээлэл технологи, цахим худалдаа, даатгал, гадаад төлбөр тооцоо сэдэвт хэлэлцүүлэг, Share Mongolia Шинэ Зеландын фермерүүдийн ашгийн төлөө бус байгууллагаас Монгол улсад хонь хяргах сургалт зохион байгуулах сургалтын мэдээлэлтэй танилцав.

Санхүүгийн зохицуулах хорооноос гадны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байгаа нийт 8 төсөл, хөтөлбөрийн мэдээллийг нэгтгэн боловсруул хамтран ажиллах боломжийг судалж байна.



САНАМЖ БИЧИГ


ХААИС-ийн дэргэдэх Арьс ширний салбарын сургалт, судалгаа инновацын төв шинээр нээгдэж Хөдөө аж ахуйн бирж нь тус төвтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.

Тус санамж бичгийн хүрээнд малчин, хоршоод, түүхий эдийн агуулах эрхлэгч нарт арьс ширэн түүхий эдийг хэрхэн зөв бэлтгэх, чанарын хамгаалалт хэрхэн хийх талаар сургалт зохион байгуулах, биржийн чанар стандарт хангасан түүхий эдийг олон улсын зах зээлд гаргахад хамтран ажиллахаар боллоо.



САНАМЖ БИЧИГ

Хөдөө аж ахуйн ХОРШООДОД дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл", "Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо" нартай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.






МАРКЕТИНГ

Компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээ мэдээллээр хангах, цахим хуудсыг хөгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын албан ёсны цахим хуудсанд цаг үеийн мэдээ, арилжааны мэдээ, оны онцлох үйл явдал, танин мэдэхүй, олон улсын мэдээ зэрэг мэдээллүүдийг цаг алдалгүй долоо хоногийн өдөр бүр системтэйгээр түгээж ажиллаж байна.

2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны байдлаар компанийн албан ёсны цахим хуудасны нийт хандалтын тоо 58,251 болж өссөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1800 гаруй хувиар өссөн байна. Цахим хуудсанд зочилсон хүний тоо 3250 болж өссөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 574 хувиар өссөн байна.





МАРКЕТИНГ

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хэвлэмэл гарын авлага, зөвлөмж зэргийг цахим хэлбэрт шилжүүлэн дижитал брошур болгон хийж гүйцэтгэн цахим хуудас, вебсайтад байршуулж эхэлсэн.

Олон нийтийн сүлжээнд түгээмэл асуулт, хариултад цаг алдалгүй хариулах, хэрэглэгчдийн сэтгэл ханамжтай байлгах зорилгоор чатбот автомат хариулагчийг суурилуулан ажиллуулж байна.

Загвар хоршооны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Сумандаа сайхан амьдаръя нэвтрүүлэгтэй хамтран нийт 10 цуврал дугаар гаргахаар төлөвлөсөн. Үүний хүрээнд Баялаг гүрэм хоршоог байгуулсан тухай, хоршооны үйл ажиллагаа зэргийг сурталчилсан эхний 6 дугаарыг Малчин ТВ болон Youtube сувгаар цацсан.



ТӨЛБӨР ТООЦОО, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Төлбөр тооцоо

Биржийн байнгын гишүүн оролцогчид клирингийн эрх авснаар баталгаат дэнчин, барьцаа хөрөнгө байршуулан өөрийн харилцагчдын гэрээний төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтой ба клирингийн бус гишүүд баталгаат болон анхдагч дэнчин байршуулан арилжаанд орох бөгөөд арилжаанд оролцогчид гэрээний үүргээ биелүүлсэн, биржид ямар нэгэн өр төлбөргүй тохиолдолд тухайн дэнчин, барьцааг буцаан шилжүүлдэг.

2022 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар нийт 523 хэлцлийн худалдах, худалдан авах гэрээг баталгаажуулж, 575.6 тэрбум төгрөгийн спот гэрээний төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн байна.

Төлбөр тооцооны үйл ажиллагаанд цахимжуулах боломжтой ажлуудыг тодорхойлж, үе шаттайгаар авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Худалдах, худалдан авах гэрээг цахимжуулах, тоон гарын үсэг ашиглах ажлын судалгаа хийгдэж, компаниудтай уулзалтуудыг зохион байгуулсан. Гишүүн оролцогчдод зориулсан биржийн төлбөр тооцооны гарын авлага боловсруулж, цахим хуудсанд байршуулах болон хэвлэмэл хэлбэрээр бэлтгэн гаргасан



Эрсдэлийн удирдлага

Компанийн зах зээл, дотоод гадаад үйл ажиллагааны эрсдэлийг илрүүлэн тодорхойлж, эрсдэлийг үнэлэх ажлын хүрээнд:

Нийт ажилтан албан хаагчдаас үйл ажиллагаа, авилга, ажлын байрны эрсдэлийг тодорхойлох тусгайлан боловсруулсан асуулгын хуудсаар авч нэгтгэн, байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийг бүртгэлжүүлэв.

Байгууллагын гадаад хүчин зүйлийн шинжилгээ /CBOT/ хийж гадаад хүчин зүйлсээс нөлөөлөх эрсдэлийг тодорхойлсон.

Байгууллагын дотоод үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох зорилгоор өнгөрсөн жилүүдэд үүссэн эрсдэлийг тодорхойлон бүртгэлжүүлсэн.

Тодорхойлсон эрсдэлүүдийг MNS ISO 31010:2016 эрсдэлийн үнэлгээний аргын дагуу эрсдэлийн үнэлгээ хийсэн.

Биржийн эрсдэлийн үнэлгээний дагуу хийгдэх арга хэмжээ буюу "Эрсдэлийн төлөвлөгөө"-г гаргасан.

ГИШҮҮНЧЛЭЛ


Байнгын гишүүн

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй “Хаан тэлмэн” ХХК, Ханбүргэд Хэнтий” ХХК, “Алтан шагай импекс” ХХК байнгын гишүүний гэрээний хугацааг сунган ажиллаж байна. Мөн үйл ажиллагаа нь зогссон байсан “Цэц инвест”, “Бадархундага оргил” байнгын гишүүнчлэлийн эрхээ сэргээн, гэрээ байгуулж дахин үйл ажиллагаа эхлүүлсэн.



Байнгын бус гишүүн

Тайлант хугацаанд биржийн байнгын бус гишүүдийг нэмэгдүүлэх тал дээр нэлээдгүй ажлыг хийж эхний хагас жилд гишүүдийн тоог 4-өөр нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажилласнаас 8 аймгийн 17 хоршоог байнгын бус гишүүнээр бүртгэж, гэрээ байгуулан арилжааны програмд бүртгэл үүсгэсэн мөн 3 хоршоог биржийн арилжаанд оролцуулаад байна.





Биржийн арилжаанд оролцогчийн тоог нэмэгдүүлж, чадавхжуулсан талаар:

Эхний хагас жилд идэвхтэй арилжаанд оролцогч итгэмжлэгдсэн агуулахыг 2-оор, хөдөө орон нутгийн итгэмжлэгдсэн агуулахыг 12-оор, нийт 14 агуулахыг итгэмжлэх төлөвлөгөөтэй ажилласнаас идэвхтэй арилжаанд оролцогч 3, хөдөө орон нутгийн 17, нийт 20 агуулахад итгэмжлэл олгож гэрээ байгуулсан. Энэ нь төлөвлөгөөгөө 145 хувиар давуулан биелүүлсэн үзүүлэлттэй байна.

Шинээр “Файнноос” ХХК, “Стар импэкс” ХХК, “Өгөөж шим” ХХК-ийн үйлдвэрийн агуулахад Биржийн итгэмжлэл олгож, арилжаанд оруулсан.

Өвөрхангай аймгийн 12 хоршооны агуулахыг биржийн итгэмжлэгдсэн агуулахад тавигдах шалгуур үзүүлэлтийн дийлэнхийг хангуулж, анхан шатны баримт бичгийн бүрдэлийг бүрдүүлүүлэн бүртгэл хийж, гэрээ байгуулсан.

2022 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар 16 аймгийн 72 сумын 64 хоршоо, 17 аж ахуй нэгж, 12 иргэний нийт 93 агуулахтай итгэмжлэлийн гэрээ байгуулсан.



Сургалт, чадавхжуулалт, хөгжүүлэлтийн хүрээнд

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын “Баялаг гүрэм” загвар хоршоог чадавхжуулах ажлын хүрээнд “Ноолуур бэлтгэх технологи” сэдэвт сургалтыг 2 дугаар сард зохион байгуулж, амжилттай суралцсан 27 хүнд батламж гардууллаа.

Шинээр Биржийн байнгын бус гишүүнээр бүртгэгдсэн хоршоодын удирдлагуудад биржийн мэдээлэл, танилцуулга хийж, биржийн арилжааны системд бараа түүхий эдийг бүртгэлжүүлэх, арилжаанд хэрхэн оролцох талаар сургалт зохионбайгуулсан.

Биржийн итгэмжлэгдсэн агуулахын түүхий эд хариуцсан ажилтныг чадавхжуулах “Биржийн бараа кодлогч”-ийн онол, дадлага хосолсон сургалтыг 2022 оны 3 сард анх удаа зохион байгуулж, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг итгэмжлэгдсэн 14 агуулахын 15 ажилтан, шинээр итгэмжлэгдсэн 5 хоршооны 5 ажилтан тус тус хамрагдаж, 20 ажилтанд “Биржийн барааны код олгогч”-ийн эрхийн үнэмлэх олгосон.

Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооноос зохион байгуулж буй хоршооны “Хууль эрх зүйн орчны өөрчлөлт” сэдэвт сургалтад биржийн үйл ажиллагаа, гишүүнчлэл, итгэмжлэлийн тухай танилцуулга бэлтгэн танилцуулж, мэдээлэл өгсөн.



Сургалт, чадавхжуулалт, хөгжүүлэлтийн хүрээнд

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоотой хамтран “Хоршоо чадавхижуулах, биржийн зах зээлийн мэдлэг олгох” онол практик хосолсон 3 өдрийн сургалт зохион байгууллалаа. Практик сургалтаар “Лора Пьяна Монголиа” ХХК-ийн түүхий эдийн агуулах, “Сор кашимер” ХХК-ийн ноолуурын үйлдвэрийн технологи үйл ажиллагаатай танилцуулж, түүхий эдийн чанар бүтээгдэхүүний чанарт хэрхэн нөлөөлдөг талаар мэдээлэл өгч, арилжаанд орох ноолуурт биет үзлэг хийж баталгаажуулалт хийх талаар мэдлэг олгосон. Нийт сургалтад оролцогчдод чадавхижуулах сургалтад хамрагдсан сертификатыг олгосон ба хоршоодын агуулахын түүхий эд хариуцсан 12 ажилтанд “Биржийн бараа кодлогчийн эрх олгох” үнэмлэхийг олгосон.





Загвар хоршоо хөгжүүлэн ажилласан талаар:

Биржийн боловсруулсан “Загвар хоршоо” техник эдийн засгийн үндэслэлийг хэрэгжүүлэх үүднээс 2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Сүмбэр багт хоршоо байгуулах анхдугаар хурлыг зохион байгуулан 43 гишүүнтэй “Баялаг гүрэм” загвар хоршоо байгуулсан.

Компани уг загвар хоршоог хөгжүүлэх, үйл ажиллагааг тогтворжуулахад авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байгаа ба төлөвлөгөөний дагуу сургалт, чадавх бэхжүүлэх ажлуудыг үе шаттай хэрэгжүүлэн, хоршоонд өдөр тутмын менежментийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Ноос бэлтгэлийг хурдан шуурхай буюу хяргах машинаар гүйцэтгэх, ноосны арилжааг зохион байгуулахаар ажиллаж байна.



Дээрх ажлын хүрээнд “Баялаг гүрэм” хоршооны 2022 оны бизнес төлөвлөгөөг боловсруулан, хоршооны тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулах, ноолуур бэлтгэх технологи сургалтыг зохион байгуулж түүхий эд бэлтгэгчийг бэлтгэх, хоршооны өрхүүдийн ноолуур бэлтгэлийн явцтай танилцан түүхий эдийн агуулахын засварын ажлыг гүйцэтгүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Загвар хоршооны таваар бэлтгэгчдийг Японы ОУ-ын Жайка "Нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө боловсруулах" төсөл, "Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалах" төсөлтэй хамтран цахилгаан хайчаар хонины ноос бэлтгэх технологийн сургалтад хамруулж мөн төслийн хөрөнгө оруулалтаар загвар хоршооны агуулахыг биржийн итгэмжлэгдсэн агуулахын шалгуур үзүүлэлт, стандартад нийцүүлэн шинэчлэн засварлаад байна.

Үйл ажиллагаатай танилцах үеэр хонь хяргах, ноос пресслэх машины талаар зочдод мэдээлэл өгч, ноос хяргах машинаар 1 хонийг 1 минут 40 секундэд хэрхэн ноосолж байгааг үзүүлсэн юм.





ДҮГНЭЛТ

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК 2022 оны эхний хагас жилд байнгын бус гишүүн хоршооны тоог нэмэгдүүлж, Хэнтий аймгийн Баян-Овоо суманд “Баялаг гүрэм” загвар хоршоог байгуулан, хоршоодыг биржийн арилжаанд оруулах ажлыг амжилттай зохион байгуулж эхэллээ.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулан, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Мөн Биржийн дотоод үйл ажиллагаанд мөрдөж буй Арилжааны журам, Гишүүнчлэлийн журам, Клиринг, төлбөр тооцооны журам, Биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох журам зэрэг журмуудыг хэлэлцэн, шинэчлэн батлаад байна

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимтай уулзалт зохион байгуулж, экспортод гаргах бараа, түүхий эдийн гарал үүслийг тодорхойлоход биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолтыг биржээс хүргүүлдэг байхаар тогтсон.



Цахим хөгжүүлэлтийн ажлын хүрээнд арилжаа, төлбөр тооцооны блокчейн програмыг сайжруулах нэмэлт ажлын даалгавар боловсруулан гүйцэтгэгчийн зүгээс хөгжүүлэлтийг хийж тус програмыг бүрэн хүлээн авч нэвтрүүллээ. Цаашид програмыг банктai холбох, биржийн дотоод гар ажиллагааг цахимжуулах, үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих бэлтгэл ажлууд хийгдэнэ.

Биржийн эрсдэлийг тодорхойлон, MNS ISO 31010:2016 эрсдэлийн үнэлгээний аргаар үнэлгээг хийж, Биржийн үйл ажиллагааны “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ын бичиг баримт, 2022-2026 онд хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг гаргаж, баталсан бөгөөд цаашид хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийн хүрээнд “Эрсдэлийн удирдлагын хороо”-г байгууллаа



ХААБ
ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ



ЦААШДЫН ТӨЛӨВ



Загвар хоршооны төлөвлөгдсөн ажлуудыг хэрэгжүүлж, ноосны болон амьд малын арилжааг зохион байгуулах.



Монгол Улсад хэрэгжиж буй хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалт, зохицуулалттай зах зээлийн хөгжилд чиглэсэн төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах.



Байнгын гишүүнийг нэмэгдүүлэх хүрээнд брокерын эрх олгох сургалтыг зохион байгуулах, сонирхогч этгээдэд дэмжлэг үзүүлэн байнгын гишүүнээр бүртгэх.



Аймгуудын Хоршоологчдын холбоо болон Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран Хоршоологчдын зөвөлгөөнийг зохион байгуулж, биржийн үйл ажиллагааг сурталчилан таниулах, хоршоодыг бүртгэлжүүлж, биржийн байнгын бус гишүүдийн тоог нэмэгдүүлэх;



ЦААШДЫН ТӨЛӨВ



Агуулах бүртгэлийн цогц системийн судалгаа, загвар дизайн болон бусад судалгааг хийж 2023 оны төсөвт суулгаж программ хангамжийг хийх

Агуулахын стандартын төслийг хэлэлцүүлгийг зохион байгуулан агуулгыг сайжруулах, эрх бүхий байгууллагад хүргүүлж батлуулах, сурталчлан таниулах

Компанийн Веб сайтын хөгжүүлэлтийг дуусгах, тестийн серверийг тогтмол ажиллуулах банкнуудтай холбогдож төлбөр тооцооны системийг автоматжуулах, багцын гэрээний дагуу e-barimt системтэй холбох.



MCE
MONGOLIAN COMMODITY
EXCHANGE



70128779, 70148779



www.mce.mn



Хөдөө Аж Ахуйн Бирж ТӨХХК



Энхтайвны өргөн чөлөө, 18А-1, Монголын
Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын
Үндэсний Холбооны байр, 2 давхар